

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн “Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОО-2024/13/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2024 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитор: С.Энхбаатар Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	9
4. Аудитын тайлан.....	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. Аудитын илрүүлэлт	13
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.02.15 № 294

танай _____-ны № _____-т

“ХЭРЛЭН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ”
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА М.АЛТАНХУЯГ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хэрлэн тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Хэрлэн тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны эцэст 2,253.6 сая төгрөгийн хөрөнгөд тооллого хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 70.2.1-д “үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/,” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

“Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь “Найрамдал цэцэрлэгт хүрээлэн” нэртэйгээр Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09/06 дугаар тогтоолоор байгуулагдаж, 2023 оны 12/02 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэмд өөрчлөлт оруулж, 2023 оны 03 сарын 03-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст 2,253.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд тооллого хийгээгүй байна.

011021160

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	218000.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	18000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	18000.00
3121	Төгрөг	0.00	18000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	18000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	200000.00
354	Хангамжийн материал	0.00	200000.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	200000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	666950317.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	666950317.02
392	Биет хөрөнгө	0.00	666950317.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	702705020.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-612741551.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	1481997560.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-928439444.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	31151135.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-11460715.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	3698636.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-3335527.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	34063545.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-30688340.15
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	667168317.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	667168317.02
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	667168317.02
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	638642318.86
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	-28525998.16
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	667168317.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	28525998.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	667168317.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	1628981644.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1548954401.53
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1548954401.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1548954401.53
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	698600000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	46886000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	803468401.53
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	80027242.54
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	80027242.54
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	0.00	80027242.54
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	961813327.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	961813327.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	960668297.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	440711241.00
210101	Үндсэн цалин	0.00	440711241.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	62411206.64
210201	Тэтгэврийн даатгал	0.00	36585879.64
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	4304220.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	12051820.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	860844.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	8608443.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	6190295.91
210301	Гэрэл, цахилгаан	0.00	2531590.91
210302	Түлш, халаалт	0.00	2817540.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	841165.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	226848840.00
210401	Бичиг хэрэг	0.00	1281687.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	221818361.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	792878.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	2955914.00
2105	Нормативт зардал	0.00	19500900.00
210502	Хоол, хүнс	0.00	4140900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	15360000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	56087482.36
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	3784892.36
210604	Урсгал засвар	0.00	52302590.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1110346.63
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	1085746.63
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	24600.00

Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	147807984.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	790000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	147017984.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1145030.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1145030.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1145030.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	667168317.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	667168317.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	825513242.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	745486000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	745486000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	745486000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	698600000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	46886000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	80027242.54
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	80027242.54
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	0.00	80027242.54
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	825495242.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	825495242.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	824350212.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	440711241.00
210101	Үндсэн цалин	0.00	440711241.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	62411206.64
210201	Тэтгэврийн даатгал	0.00	36585879.64
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	4304220.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	12051820.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	860844.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	8608443.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	6190295.91
210301	Гэрэл, цахилгаан	0.00	2531590.91
210302	Түлш, халаалт	0.00	2817540.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	841165.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	227048840.00
210401	Бичиг хэрэг	0.00	1481687.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	221818361.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	792878.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	2955914.00

Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	0.00	19500900.00
210502	Хоол, хүнс	0.00	4140900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	15360000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	66587382.36
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	10499900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	3784892.36
210604	Урсгал засвар	0.00	52302590.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1110346.63
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	1085746.63
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	24600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	790000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	790000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1145030.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1145030.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1145030.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	18000.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-28,525,998.16	-28,525,998.16
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-28,525,998.16	-28,525,998.16
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	28,525,998.16	0.00	28,525,998.16
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	667,168,317.02	667,168,317.02
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	28,525,998.16	638,642,318.86	667,168,317.02

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн “Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь орон сууц, гэр хорооллын ахуйн хог хаягдал, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн буюу ахуйн хог хаягдлыг цуглуулан ачилт, тээвэрлэлт хийх үйл ажиллагаа явуулдаг, Хэрлэн сумын Засаг даргын дэргэдэх байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь Хог хаягдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

“Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь “Найрамдал цэцэрлэгт хүрээлэн” нэртэйгээр Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09/06 дугаар тогтоолоор байгуулагдаж, 2023 оны 12/02 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэмд өөрчлөлт оруулж, 2023 оны 03 сарын 03-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Хэрлэн тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн Сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгээгүй, Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 667.2 сая төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	18.0	18.0
Бараа материал	0.0	200.0	200.0
Үндсэн хөрөнгө	0.0	666,950.3	666,950.3
Нийт хөрөнгө	0.0	667,168.3	667,168.3
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	0.0	667,168.3	667,168.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0.0	667,168.3	667,168.3

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу төрийн өмчит үйлдвэрийн газар нь тухайн оны санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж биелэлтийг хангах үүрэгтэй.

Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 15/01 тогтоолоор “Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,250.0 сая төгрөгөөр баталсан байна. Тайлант оны батлагдсан төсвийг 250.0 сая төгрөгөөр бууруулж 1,000.0 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 698.6 сая төгрөгийн санхүүжилт, хог хаягдлын хураамжаар 80.0 сая төгрөг, бусад орлогоор 46.9 сая төгрөгийг бүрдүүлж, 825.5 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 825.5 сая төгрөг буюу 82.5 гүйцэтгэлтэй байна. Энэ нь хог хаягдлын хураамжийн орлого холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Энхбаатар гүйцэтгэж, хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

“Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 03/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 962.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 14.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар болгон өөрчлөөгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Хэрлэн тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

“Хэрлэн тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ыг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Залруулсан алдаа:

- Худалдан авсан 0.2 сая төгрөгийн тамга тэмдгийг данс бүртгэлд тусгасан ч зардлаар бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 2,253.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2,253.6 сая төгрөгийн 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Байгууллагын төсвөөс гар утасны төлбөрт 0.3 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.1.гар утасны зардал;” гэж заасныг зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

1. Аймгийн ИТХ-ын 2023 оны 15/09 дугаар тогтоолоор 627.5 сая төгрөгийн балансын үнэтэй конторын барилга, 44.5 сая төгрөгийн балансын үнэтэй тээврийн хэрэгслийн 2 граш, 20.8 сая төгрөгийн балансын үнэтэй орон сууцны барилга шилжиж ирсэн ч барилгын газар эзэмших эрхийг өөрийн байгууллагын нэр дээр шилжүүлэн аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. Үүнд: 14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “газар дээрх үл хөдлөх хөрөнгө нь тухайн газрын бүрдэл хэсэг байх.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2. Тайлант оны эцэст 2,253.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд тооллого хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 70.2.1-д “үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-ээс 31-ний дотор/;” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. “Хэрлэн тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ нь санхүүгийн тайланг Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хуульд нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, нийтэд мэдээлнэ. Энэ ангилалд доор дурдсан аж ахуйн нэгж, байгууллагыг заавал хамруулна: 4.2.4.төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж;”, Сангийн Сайдын 2017 оны

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар болгон хэрэглээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ”, MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т “Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна” гэснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т нийцүүлэн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар болгон өөрчлөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасан. Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авсан тамга тэмдгийг зардлаар бүртгэсэн.	1	200.0	-	-	1	200.0	1	200.0	-	-	-	-
Дүн	1	200.0			1	200.0	1	200.0	-	-	-	-

Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гар утасны зардалд 247.3 мянган төгрөгийг зарцуулсан.	1	247.3	1	247.3								
Тайлант оны эцэст 2,253,615.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд тооллого хийгээгүй.	1	2,253,615.9			1	0						
Санхүүгийн тайланг Сангийн Сайдын аж ахуйн нэгжид зориулсан тушаалыг мөрдөөгүй.	1	0			1	0						
Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй.	1	0					1	0				
Аймгийн ИТХ-ын 2023 оны 15/09 дугаар тогтоолоор 627.5 сая төгрөгийн балансын үнэтэй конторын барилга, 44.5 сая төгрөгийн балансын үнэтэй тээврийн хэрэгслийн 2 граш, 20.8 сая төгрөгийн балансын үнэтэй орон сууцны барилга шилжиж ирсэн ч барилгын газар эзэмших эрхийг өөрийн байгууллагын нэр дээр шилжүүлэн аваагүй.	1	0			1	0						
Дүн	4	2,253,863.2	1	247.3	3	2,253,615.9	1	0	0	0	0	0